

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР 8 ДУГААР САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

ГАЗРЫН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН:

Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 34 дүгээр тушаалаар батлагдсан “Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын аргачилсан заавар”-ын дагуу Сүмбэр сумын хот тосгон, бусад суурин газарт 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдөр мониторингийн 10 цэгт хөрсний эрүүл ахуй, хүнд металлын бохирдлын судалгаа хийж, бохирдлын дээж авч лабораторийн шинжилгээнд хамруулах, бохирдлыг тодорхойлох судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.



Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг ГХГЗЗ Газрын даргын 2015 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн А/105 тоот тушаалаар батлагдсан “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторинг хийх аргачлал”-ын дагуу аймгийн хэмжээнд нийт 3 сумын 10 багт, 2023 оны 08 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд 48 цэгийг төлөөлүүлэн сонгож бэлчээрийн даац тодорхойлох хээрийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.


Энэхүү ажлын зорилго нь бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын өөрчлөлтийг тогтсон хугацаанд тогтмол хянах, өөрчлөлтийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, үнэлэлт, дүгнэлт өгөх, холбогдох мэдээллийн санг үүсгэн хэрэглэгчдийг мэдээллээр хангах, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавихад суурь мэдээлэл бий болгоход орших юм.



Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 04 дүгээр тогтоолоор сумын 2023 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд нэмэлт тодотголоор 2 байршилд 5135 га газрыг төрийн байгууллагад олгохоор баталлаа. Үүнд: Говьсүмбэр аймгийн Тагнуулийн хэлтэсд 135 м2 газар, Говьсүмбэр аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт 5000 м2 газрыг тус тус эзэмшүүлсэн байна.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТЭС:

1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага барилга байгууламжийг ашиглалтад оруулахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтын мэдээллийг бэлтгэн байгууллагын цахим хаяг govisumber.gazar.gov.mn болон бусад холбогдох цахим хаягаар иргэд олон нийтэд мэдээлэлж байна.




Цэвэрлэх байгууламж

2. Польш улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжүүлж буй "Говьсүмбэр аймгийн 2000м3 бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөх, шинэчлэх шинээр барих" төслийн ажлын гүйцэтгэгч "Growing value" LLC ажиллаж байна 2023.08.08 өдрийн байдлаар цэвэрлэх байгууламж, конторын барилгын газар шороо, цутгамал төмөр бетон суурийн ажил хийгдэж байна. гүйцэтгэл 80 хувьтай, гадна цахилгаан хангамжийн ажил 95 хувьтай хийгдэж байна.



3. Боржигон чуулгын барилга

Барилгын дотор туслах ханын өрлөгийн ажил хийгдэж байна үзвэрийн заалны металл ферм угсрагдсан. Барилга угсралтын ажлын гэрээ -2 нэмэлт ажлын төсөв тооцоог БХТөвд магадлалд батлуулахаар өгсөн. Барилгын төсвөөс хамаарсан өөрчлөлт хүлээгдэж байгаа тул барилгын ажил удаашралтай байна.



4. **Халуун усны барилга** Халуун усны барилгын ажил эхэлж байна. гадна ханын өрлөгийн ажил хийгдэж байна талбайд өнгөлгөөний тоосго дулаалга ирсэн байна. Өрлөгийн ажил хийгдэж байна.

5. **Аймгийн төвийн авто замын ажил 2,8км**

Авто замын 4 хэсэг ажлын гүйцэтгэл хэсэг тус бүр 60-90 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна.



6. **Тээвэрчдийн өч 0,36 км автозамын ажил**

Ажлын гүйцэтгэл 70 хувьтай авто хамшлага суусан элс хайрганы цементны хольц дээр даацын хавтан суулгах ажил хийгдэж байна.



7. **Тээвэрчдийн өч гэрэлтүүлэгийн ажил**

Ажлын гүйцэтгэл 95 хувьтай захиалагч хяналтын байгууллагаас угсралтын ажилтай холбоотой тодорхой үүрэг даалгаврыг өгсөн биелэлтийг хангуулахаар ажиллаж байна.



Улсын комисс ажилласан байдал

Төрийн банкны Шивээговь суман дах Тооцооны төвийн барилга

Тооцооны төвийн барилгад 2023.08.21-ний өдөр Улсын комисс ажиллаа. Барилгын ажлын гүйцэтгэгчээр: “Монничкон трейд” ХХК, зураг төслийн байгууллага: “Тоонот” ХХК, Ерөнхий захиалагч: Төрийн банк Улсын комисс 11 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах шийдвэр гарсан байна.

